



IAS INTERNATIONAL
ACCREDITATION
SERVICE®

ISO 9001:2015 Certified Organization



ЖИЛИЙН ТАЙЛАН | 2018



АГУУЛГА

Эрхэм зорилго
Гүйцэтгэх захирлын мэндчилгээ
Компанийн танилцуулга
Санхүүгийн үзүүлэлтүүд
2018 оны онцлох үйл явдал
Даатгалын үйл ажиллагаа
Давхар даатгал
Даатгалын зах зээлийн мэдээлэл
Хүний нөөц
Эрсдэлийн удирдлага
Удирдлагын баг
Компанийн бүтэц
Хянан нийцүүлэх үйл ажиллагаа
Төлөөлөн удирдах зөвлөл
Хараат бус аудиторын дүгнэлт



ЭРХЭМ ЗОРИЛГО

ХЭТИЙН ЗОРИЛТ

Бид Монголдоо дэлхийн түвшний санхүүгийн үйлчилгээтэй байгууллага болно.



ЭРХЭМ ЗОРИЛГО

Эрдэнэт хүмүүн, Эх дэлхий, Эрүүл ашгийг эрхэмлэн харилцагчиддаа үнэ цэнэтэй санхүүгийн үйлчилгээг хүргэж, насан туршийн түнш нь байх болно.

Байгуулагдсан он

2001

Салбар

21

Ажилтан

105

Төлөөлөгч

139

“ Таны аз жаргалтай мөч бүрийн төлөө хамтдаа... ”



ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

Хүндэт хамт олон, хамтрагчид болон эрхэм хүндэт харилцагчиддаа,

Зарим даатгалын компаниудын эзэмшигч өөрчлөгдөж, компанийхаа хувьцааг анх удаагаа хөрөнгийн зах зээл дээр худалдан борлуулсан зэрэг шинэлэг үйл явдлууд тохиосон энэ улиран одож буй жилд Тэнгэр Даатгал компани тун амжилттай ажиллалаа. Эдгээр үйл явдлууд нь даатгалын салбарын зах зээлийн оролцогчдын тэлэлт буурч, өрсөлдөөн нэмэгдэж байгааг харуулсан хэрэг юм. 2018 онд манай хөрөнгийн хэмжээ 4.2 тэрбум төгрөгөөс 23.5 тэрбум төгрөг болтлоо өсч, нийт хөрөнгийн хэмжээ 23%-иар нэмэгджээ. Манай компанийн нийт хураамжийн хэмжээ 19%-иар өсч 14.5 тэрбумд хүрсэн бол даатгалын цэвэр хураамж 9.5%-иар нэмэгдэж 8.5 тэрбум төгрөгт хүрсэн үзүүлэлттэй байгаа юм. Бизнесийн тэлэлт, даатгалын нөхөн төлбөр нэмэгдсэнээс болж үйл ажиллагааны зардал өссөний улмаас нийт ашгийн хэмжээ бидний тооцоолж байснаас 12.8%-аар бага буюу 1.9 тэрбум төгрөг гарсан байна. Бид давхар даатгал, санхүүгийн найдвартай байдал, чанарыг сайжруулж өөрсдийн даатгалын үйлчилгээгээ олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартад хүргэх, чадавхийг бий болгохыг хичээж ажилласаар ирсэн билээ. Бүрэн интеграцилагдсан онлайн даатгалын платформыг амжилттай нэвтрүүлээ. Манай компани ISO 9001:2015 стандартыг амжилттай нэвтрүүлж, харилцагчдынхаа хэрэгцээ шаардлагад нийцсэн даатгал болон нөхөн төлбөрийн үйлчилгээг чин сэтгэлээсээ хийж гүйцэтгэсээр байна. Энэхүү зорилгодоо хүрэхийн тулд харилцагчийн үйлчилгээний хэлтэс, үйлчилгээний төвийг шинээр бий болгосон. Мэргэжлийн даатгалын ажилтнууд, эрсдэлийн менежерүүд болон даатгалын бусад мэргэжилтнүүддээ тохирсон суралцах боломжийг олгох нь тогтвортой хөгжилд хүргэх бидний түлхүүр юм. Бид ажилтнуудаа олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн сертификат авахад нь үргэлж дэмжиж ажилладаг. Жил бүрийн тайлангаараа дамжуулан баг хамт олон, нийт хамтран ажилладаг байгууллага, эрхэм хүндэт харилцагчиддаа бүтэн жилийн турш Тэнгэр Даатгал компанийг дэмжин ажилласанд талархаж байгаагаа илэрхийлье!

Хүндэтгэсэн,
Ойбек Н. Халилов
Гүйцэтгэх захирал




КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

Тэнгэр Даатгал компани нь анх Тэнгэр Санхүүгийн Нэгдэл болон Петровис компанийн хөрөнгө оруулалттайгаар 2001 онд байгуулагдсан. Монголын даатгалын зах зээлд 20 орчим жил тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа, харилцагчийн эрсдэлийн удирдлагын цогц шийдлийг санал болгон ажилладаг харилцагчдын итгэл найдварыг бүрэн хүлээсэн даатгалын салбарын тэргүүлэгч компани юм.


Харилцагчийн эрсдэлийн удирдлагын цогц шийдлийг санал болгон ажилласнаар харилцагчдын итгэл, найдварыг бүрэн хүлээсэн, хариуцлагатай, ил тод байдлыг эрхэмлэдэг хамгийн сайн засаглалтай даатгалын салбар дахь тэргүүлэгч компанийн нэг юм. Тэнгэр Даатгал ХХК нь санхүүгийн ил тод үйл ажиллагаатай, нийгмийн хариуцлага, хамтын ажиллагааны цар хүрээ, сайн засаглалыг баримтлагч зэргээрээ Монголын даатгалын зах зээлд тэргүүлсээр байх болно. Бид Монгол улс даяар нийт 21 салбар, 139 төлөөлөгч, 23 зуучлагч компани, ХасБанк, ХаанБанк, Монголын Үндэсний Хөрөнгө оруулалтын банкуудаар даатгалын үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай чирэгдэлгүй хүргэн ажиллаж байна.

2018 оны 4-р улирлын байдлаар Тэнгэр Даатгал компани Монгол улсын нутаг дэвсгэрт хэрэгжиж байгаа гадаад, дотоодын томоохон дэд бүтцийн, уул уурхайн төслүүд болон Монголын ТОП-100 аж ахуйн нэгжүүдийн 60 гаруй хувьд даатгалын үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна.


САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД




НИЙТ ХУРААМЖ




НИЙТ ХӨРӨНГӨ




ЦЭВЭР АШИГ



ЭЗДИЙН ӨМЧ



НӨӨЦ САН



ЦЭВЭР НӨХӨН ТӨЛБӨР

2018 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



ЦАХИМ ДААТГАЛЫН ШИНЭ СИСТЕМ НЭВТРҮҮЛЛЭЭ

Тэнгэр Даатгал ХХК нь бүтээгдэхүүн, үйлчилгээгээ иргэдэд илүү ойртуулж, түргэн шуурхай, хүртээмжтэй болгохоор ажилласны үр дүнд цахим даатгалын шууд борлуулалтын шинэ сувгийг зах зээлд амжилттай нэвтрүүлээ.



ТЭНГЭР ДААТГАЛ ХХК НЬ МОНГОЛД АНХ УДАА AMERICAN INTERNATIONAL GROUP-ТЭЙ ОНЦГОЙ ЭРХТЭЙГЭЭР ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭГ БАЙГУУЛЛАА

Монголын даатгалын зах зээлд давхар даатгалын чадавхиар тэргүүлэгч Тэнгэр Даатгал ХХК нь өнөөдөр American International Group (AIG)-тэй Монголын зах зээлд онцгой эрхтэйгээр хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зурлаа. AIG буюу American International Group нь зах зээлийн хөрөнгөжилтийн хэмжээгээрээ дэлхийн хамгийн том 10 даатгалын компаниудын жагсаалтад багтсан төдийгүй Fortune сэтгүүлийн шилдэг 500 болон Forbes-ийн шилдэг 2,000 компаниудын

80%-д нь санхүү, даатгалын үйлчилгээ үзүүлдэг. Энэхүү онцгой эрхтэйгээр хамтран ажиллах гэрээнд Тэнгэр Даатгал ХХК-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал ноён Ойбек Н.Халилов, AIG-ийг төлөөлж Ази Номхон Далайн Бүсийн Үндэстэн дамнасан эрсдэл хариуцсан тэргүүн дэд ерөнхийлөгч ноён Тони МакХарг нар гарын үсэг зурсан бөгөөд тус гэрээ нь хэрэгжиж эхэлснээр Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй дотоодын болон гадаадын байгууллагууд Тэнгэр Даатгалаар дамжуулан AIG группийн олон улсын даатгалын үйлчилгээ болон давхар даатгалд бүрэн хамрагдах боломж бүрдэж байна.



ТЭНГЭР ДААТГАЛ ISO 9001: 2015 ЧАНАРЫН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦООНЫ СТАНДАРТЫГ ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА НЭВТРҮҮЛЛЭЭ

Тэнгэр Даатгалын нийт 20 хүний бүрэлдэхүүнтэй төслийн баг 4 сарын хугацаанд Чанарын удирдлагын тогтолцоо ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлээ. Төслийн хугацаанд ProcessLogix компаниар зөвлүүлж IAS (International Accreditation Service) байгууллагаас хүлээн зөвшөөрөгдсөн олон улсын стандартчиллын LMS Certification Limited байгууллагаар баталгаажуулалтын гэрчилгээгээ 2018 оны 09 дүгээр сард гардан авлаа. Төслийн хугацаанд байгууллагын нэгж бүр үйл

ажиллагааны процессыг баримтжуулах, болзошгүй эрсдэлийн үнэлгээ хийх, харилцагч болон оролцогч талуудын шаардлага, сэтгэл ханамжийг үнэлж тасралтгүй сайжрах боломжийг бий болгохоор зорьсон юм. ISO стандартуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлснээр Монголын компаниуд олон улсын жишигт хүлээн зөвшөөрөгдөхөд нэг алхам ойртох юм.



ТОМООХОН ГАЛЫН УЛМААС ҮҮССЭН 1,7 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН ХОХИРЛЫГ ТӨЛЖ БАРАГДУУЛЛАА

Бармаш ХХК-ийн байранд 2017 оны 11 сард гал гарч их хэмжээний хохирол учирсан билээ. Тус барилгын талбайг түрээслэгчдийн нэг нь Байгууллагын ерөнхий хариуцлагын даатгалаар даатгуулсан байсан тул холбогдох эрх бүхий байгууллагуудын дүгнэлтийн актыг үндэслэн Тэнгэр Даатгал ХХК нь нийт 1.7 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг барагдуулсан. Давхар даатгалын болон эрсдэлийн удирдлагын бодлогын хүрээнд бид тус эрсдэлийг 100% давхар даатгалд даатгуулсан байсан бөгөөд энэхүү өндөр дүнтэй нөхөн төлбөрийг давхар даатгалын компаниар төлүүлж ажилласан юм.



ТЭНГЭР ДААТГАЛ ХХК “САНХҮҮГИЙН ФОРУМЫГ” AIG ГРУПП-ТЭЙ ХАМТРАН ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Тэнгэр Даатгал ХХК-иас гурав дахь жилдээ харилцагч, хамтрагч байгууллагуудынхаа удирдах ажилтнуудад зориулж САНХҮҮГИЙН ФОРУМ-ыг зохион байгууллаа. Энэ жилийн Санхүүгийн форумыг American International Group (AIG) хамтран зохион байгуулсан. Форумд AIG группийн Ази Номхон далайн орнуудын Санхүүгийн даатгал хариуцсан захирал ноён Дэвид Хо, олон улсын болон дотоодын санхүү, даатгалын туршлагатай мэргэжилтнүүд урилгаар хүрэлцэн ирж Монгол Улсын макро эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал,

удирдах ажилтнуудад тулгардаг эрсдэлүүд, байгууллагын эрсдэлийн удирдлагын талаарх дэлхийн чиг хандлага болон цахим эрсдэлийн талаар илтгэл тавьж өөрсдийн туршлагаас хуваалцлаа. Энэ удаагийн үйл ажиллагаанд нийт 100 гаруй байгууллагын төлөөлөл оролцсон. Сэтгүүлчдэд өгсөн ярилцлагадаа, “Бид Санхүүгийн Форумыг зохион байгуулж байгаа нь Монгол улсад олон улсын даатгалын жишгийг тогтоох, байгууллагын сайн засаглалыг хөгжүүлэхэд ихээхэн ач холбогдолтой” хэмээн Тэнгэр Даатгал ХХК-ийн Гүйцэтгэх захирал ноён Ойбек Н.Халилов онцолсон юм.



ТЭНГЭР ДААТГАЛ ХХК НЬ МОНГОЛ ДАХ ХЯТАДЫН ХУДАЛДААНЫ ТАНХИМТАЙ ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭ ҮЗЭГЛЭЛЭЭ

2018 онд Тэнгэр Даатгал ХХК нь БНХАУ-ын Монгол Улс дахь Зун Хуа нийгэмлэгтэй албан ёсны хамтын ажиллагааны гэрээ байгууллаа. Энэхүү гэрээний хүрээнд тус нийгэмлэгийн гишүүдэд зориулж түргэн шуурхай даатгалын үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.

ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Тэнгэр Даатгал компанийн стратеги нь өргөн хүрээтэй бүтээгдэхүүнийг өөрийн салбар нэгж болон борлуулалтын олон талт сувгаар дамжуулан бүх сегментийн харилцагч нарт хүргэхэд оршино. Даатгалын үйлчилгээний хэрэгцээ өдрөөс өдөрт өсч буй өнөө үед бид хүрэлцээ, хүртээмжтэй байдлаа сайжруулах үүднээс боломжит бүх борлуулалтын сувгаа ашиглан хувь хүн, аж ахуйн нэгжүүдэд үйлчилгээгээ хүргэж байна. Бид эдгээр борлуулалтын сувгаа ашиглан 40000 иргэн, 1800 гаруй аж ахуйн нэгжид даатгалын үйлчилгээ хүргэлээ. Бид дараах зорилтод чиглэн ажилладаг. Үүнд:

- Шинэлэг, үр ашигтай байдлаар харилцагчдад илүү сайн үйлчилгээ үзүүлэх;
- Санхүүгийн болон эдийн засгийн зорилтот гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө хүрэх;
- Даатгалын шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх;
- Хөрөнгө оруулалтыг идэвхтэй удирдах;
- Урт хугацааны өсөлтийн платформыг бий болгох, нутагшуулах.

Тайлант хугацаанд бид үндэстэн дамнасан корпорациудын зарласан нээлттэй тендерт амжилттай оролцож даатгалын үйлчилгээ үзүүлсэн. Олон улсын болон Монголын тэргүүлэх байгууллагуудын эрсдэлийн удирдлагын зөвлөхийн хувьд бид дэлхийн стандартад нийцэх даатгалын үйлчилгээг байнга сайжруулан хүргэсээр байна. Мөн цаашид илүү олон бүтээгдэхүүн хөгжлүүлж, сайжруулж даатгуулагчдын хэрэгцээ шаардлагыг ханган ажиллахыг зорьж байна



ДАВХАР ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Тэнгэр Даатгал ХХК нь давхар даатгалын чадавхиар Монгол Улсын зах зээлд тэргүүлэгч бөгөөд олон улсын нэр хүнд бүхий давхар даатгалын компаниудтай хамтран ажилладаг.

Даатгалын зах зээл дээрх хамгийн өндөр хамгаалалт болох 15 сая долларын үнэлгээ бүхий “Трити” буюу багцын давхар даатгалын хамгаалалттай бөгөөд дараах төрлийн даатгалаар хүлээн авсан бүх эрсдэл шууд давхар даатгалын хамгаалалтад ордог. Бидний хүлээн авдаг Хөрөнгийн даатгал, Барилга угсралтын даатгал, Ачаа тээврийн даатгал, Байгууллагын хариуцлагын даатгал, Ажил олгогчийн хариуцлагын даатгал, Гэнэтийн ослын даатгал, Тусгай зориулалтын машин механизм, Хүнд даацын тээврийн хэрэгслын даатгал болон Мэргэжлийн хариуцлагын даатгалын эрсдэл нь автоматаар шууд давхар даатгалын хамгаалалтанд орж байдаг.

Бид олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч Standard & Poor's, Moody's, Fitch Rating болон A.M.Best зэрэг агентлагуудаас А+ буюу түүнээс дээш зэрэглэл бүхий давхар даатгалын компаниуд болон олон жилийн туршлага бүхий давхар даатгалын брокерийн компаниудтай хамтран ажиллаж байна.

Тэнгэр Даатгал ХХК нь 2010 оноос олон улсын нэр хүнд бүхий “Chubb”, 2014 оноос Forbes сэтгүүлийн 500 компанийн дийлэнхийг даатгагч болох “American International Group /AIG/”-тэй тус тус хамтран ажиллаж байгаа бөгөөд 2018 оноос эдгээр давхар даатгалын компанийн Монгол дахь албан ёсны түнш даатгалын компани болсон. Бид олон улсын амжилттай харилцаагаараа дамжуулан дотоодын даатгалын зах зээлийг хөгжүүлэхэд өөрсдийн хувь нэмрийг оруулж байгууллагуудад даатгалын боловсрол, эрсдэлийн удирдлагын цогц шийдлийг хүргэдэг бөгөөд дотоодын үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ, дэд бүтэц, уул уурхай гэх мэт бүхий л салбарын эрсдэлийг даатган ажилладаг.



ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ

БОРЛУУЛАЛТЫН СУВГУУД


2018 онд эдийн засгийн үзүүлэлт сайжирч даатгалын салбарын өсөлт эрчимжсэн жил байлаа. Салбарын нийт хураамж 24%-иар, цэвэр хураамж 29%-иар тус тус өссөн нь Гэнэтийн осол эмчилгээний даатгал, Авто тээврийн хэрэгслийн даатгал, Хариуцлагын даатгалын хэлбэрүүд тус бүр 30%-иас илүү өссөнтэй холбоотой. Тэнгэр даатгалын хувьд нийт хураамж 19%-иар өссөн ба өсөлтийн гол шалтгаан нь шууд борлуулалт, түншлэл болон орон нутгийн салбаруудын өсөлт өндөр гарсантай холбоотой юм.

НӨХӨН ТӨЛБӨР

2018 онд цэвэр нөхөн төлбөр 701.4 сая төгрөгөөр (30%) өсч 3.05 тэрбум төгрөгт хүрсэн. Гэнэтийн осол эмчилгээний даатгал болон авто тээврийн хэрэгслийн даатгалын нөхөн төлбөрийн хэмжээ(severity) өссөнөөр хохирлын харьцаа 53%-д хүрсэн. Ингэснээр компанийн хэмжээнд цэвэр хохирлын харьцаа 43%-д хүрсэн байна..

АШИГТ АЖИЛЛАГАА

Хэдийгээр ашгийн хэмжээ салбарт эхний гуравт байгаа хэдий ч 2018 оны цэвэр ашиг 1.9 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 13%-иар буурсан нь үйл ажиллагааны зардлын өсөлт болон нөхөн төлбөрийн зардлын өсөлттэй холбоотой. 2018 онд бидний хөрөнгийн хэмжээ 4.2 тэрбум төгрөгөөр нэмэгдэн 23.5 тэрбумд хүрч, хувь нийлүүлсэн хөрөнгийн өгөөж 23% болсон. Хосолмол харьцаа 7.9%- иар өсч 104.1%-д хүрсэн байна.



Эх сурвалж: СЗХорооны тайлан



ХҮНИЙ НӨӨЦ

Байгууллагын тогтвортой гүйцэтгэлийг хангах

Тэнгэр Даатгалын ирээдүйн амжилтыг бататгахад хүний нөөц чухал үүрэг гүйцэтгэдэг. Үүний тулд ажилтнууддаа хөгжин дэвших, байгууллагын тогтвортой гүйцэтгэлийг хангахуйц орчин бүрдүүлэх зорилго бүхий урт хугацааны хамтын ажиллагааг бид төлөвлөн ажиллаж байна. Тодруулбал хүний нөөцийн урт хугацааны стратегийн дараах чухал зорилтыг тодорхойлсон. Үүнд:


- Бизнесийн үр дүнд хүрэхийн тулд хүний нөөцийн ур чадварыг илүү зүй зохистой хөгжүүлэх;
- Байгууллагын хүний нөөцийн эрсдэлийг хянаж, ажилтнаа идэвхижүүлэх;
- Менежер, ажилтнуудын чадавхийг бэхжүүлэх;

Бид ажилтнаа илүү бүтээмжтэй, үр дүнтэй ажиллахад шаардлагатай олон хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, ажилтнууддаа шинэ ажил үүрэг нэмэхэд тэдэнд шаардлагатай ур чадваруудыг хөгжүүлэх, компани дотроо өсөн дэвших, өөрийгөө хөгжүүлэх боломжийг онцгой анхаарч ажилласан.

Ажилтнуудаа хөгжүүлэн, ирээдүйн удирдагчаа бэлтгэх

Талент үнэлгээг хэрэгжүүлснээр удирдлагууд ажилтныхаа мэдлэг, ур чадварыг тодорхойлж, тэднийг дараагийн шинэ сорилтод бэлтгэхэд их сайн түлхэц болж өгч чадсан.

Тэнгэр Даатгал 2018 онд хүний нөөцийн сургалтын зардалд 118 сая төгрөг зарцуулсан бөгөөд нийт 2770 цагийн сургалт зохион байгуулсан. 2018 онд сургалт хөгжлийн хөрөнгө оруулалт өмнөх онтой харьцуулахад 6 хувиар нэмэгдэж хүний нөөцийн эргэц 10%-тай байсан. Чадварлаг ажилтнаа хадгалж үлдэх бидний гол хүчин зүйл нь мэргэжлийн ур чадвараа ахиулахад анхаарсан сургалт хөгжлийн хөтөлбөрт түлхүүр ажилтнуудаа хамруулах, ажил амьдралын тэнцвэртэй байдлыг мөн санхүүгийн талаас дэмжих өргөн хүрээний ажлуудыг зохион байгуулсанд оршдог.



ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Эрсдэлийг хүлээн авах нь даатгалын бизнесийн нэгээхэн хэсэг боловч урьдчилан тодорхойлсон эрсдэлийн аппетитын хүрээнд хүлээн авч буй эрсдэлээ ойлгож, журмын дагуу шийдвэр гаргах ёстой.

Тэнгэр Даатгалын эрсдэлийн удирдлагын функцийн зорилго нь эрсдэлийн удирдлагыг бизнесийн өдөр тутмын үйл ажиллагаа, стратеги төлөвлөлтөд суулгаж тогтвортой өрсөлдөх давуу байдлыг бий болгоход оршино.

“Эрсдэлийн удирдлагын тогтолцоо” нь байгууллагын эрсдэлийн удирдлагын гол бичиг баримт юм ба үүгээр байгууллагын хэмжээнд ашиглагдах эрсдэлийн удирдлагын стандарт, хэмжээг зааж өгсөн. Энэхүү бичиг баримт нь эрсдэлийн удирдлагын тогтолцоо хэрхэн ажиллах, тодорхойлсон эрсдэлийн дагуу эрсдэлийг үнэлэх мөн байгууллагын хүрээнд эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээг тогтоож өгсөн байдаг. Эрсдэлийн аппетит нь голлох харьцаануудыг олон сценарид зорилтот түвшнээс хазайх хазайлтын хүлээн зөвшөөрөгдөх хэм хэмжээг заана. Эрсдэлийн аппетит нь голлох харьцаануудыг олон сценарид зорилтот түвшнээс хазайх хазайлтын хүлээн зөвшөөрөгдөх хэм хэмжээг заана.

Тэнгэр Даатгалын эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь гурван шатны хамгаалалтын системд суурилсан бөгөөд ингэснээр ТУЗ-өөс баталсан эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээнд ажиллаж буйг бататгана.

Бизнес, нөхөн төлбөр болон бусад дэмжих үүрэгтэй функцууд өдөр тутмын үйл ажиллагаандаа учрах эрсдэлийг удирдах бөгөөд 1 дүгээр шатны хамгаалалтыг бий болгох юм. Эрсдэлийн удирдлагын функц нь 2 дугаар шатны хамгаалалт бөгөөд хүлээн авч буй эрсдэл нь стратегитай уялдаж буй эсэх, эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээ, хязгаарын зохистой эсэхийг шалгаж, учирч болох эрсдэлийг хянах үүрэгтэй. Дотоод аудитын функц нь дотоод хяналтын систем, санхүүгийн болон үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагад хараат бус, бодит үнэлгээ өгөх үүрэгтэй бөгөөд 3 дугаар шатны хамгаалалт юм.

Тэнгэр Даатгал ХХК нь эрсдэлийн тайлангаа Тэнгэр Санхүүгийн Нэгдлийн хэмжээнд тогтмол танилцуулан ажилладаг. Нэгдлийн хэмжээнд удирдах ажилтнууд болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн түвшинд эрсдэлийг удирдах журамтай. ТСН-ийн Эрсдэл хариуцсан захирал нь охин компаниудын эрсдэлийн удирдлагын функцыг хариуцан ажилладаг. ТСН-ийн Эрсдэл хариуцсан захирал нь Тэнгэр Даатгалын эрсдэлийн удирдлагын функц санхүүгийн нөөц бололцоо, эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээтэй уялдаж байгаа эсэхийг нэгдсэн байдлаар үнэлж, хянадаг. Мөн байгууллагын хэмжээнд сайн ажиллаж чадах эрсдэлийн удирдлагын үндэс суурь бий болгохоор ажиллаж байна.



Эрсдэлийн төрөл

Тэнгэр Даатгал нь үйл ажиллагаатайгаа холбоотой дараах төрлийн эрсдэлүүдийг хянаж ажиллаж байна:

- **Даатгалын эрсдэл** - гэж андеррайтингийн бүрэн бус үнэлгээнээс үүдэх эрсдэл, тохиромжгүй хураамжаас үүдэн гарах хохирол, хохирлыг нөхөн төлөхөд хангалтгүй нөөц сан болон байгалийн гамшгаас учрах эрсдэл;
- **Зээлийн эрсдэл** - гэж төлбөр буюу авлага төлөгч этгээдийн төлбөрийн чадваргүй болох эсвэл төлбөр төлөх сонирхолгүйгээс үүдэн гарах санхүүгийн зардал, мөн бонд гаргагч байгууллага (хөрөнгө оруулалтын багцад байгаа бондын), хамтран ажиллагч байгууллагууд, зуучлагч байгууллагын зээлдэх чадварын үнэлгээнд өөрчлөлт орсноос үүдэн гарах санхүүгийн зардал;
- **Зах зээлийн эрсдэл** - гэж санхүүгийн зах зээлийн эсвэл үнийн өөрчлөлтөөс шалтгаалан эдийн засгийн үнэлгээний болон ашгийн алдагдал хүлээх эрсдэл;
- **Үйл ажиллагааны эрсдэл** - гэж тохиромжгүй эсвэл амжилтгүй болсон дотоод процесс, хүн, систем болон гадаад нөлөөнөөс үүдэн гарах эрсдэл (хуулийн эрсдэл орно);
- **Хөрвөх чадварын эрсдэл** - гэж санхүүгийн хариуцлагаа биелүүлэхийг тулд хөрөнгийг бэлэн мөнгөнд түргэн хугацаанд хөрвүүлэх чадваргүйгээс үүдэн гарах эрсдэл;
- **Хянан нийцүүлэлтийн эрсдэл** - гэж хууль, журам, бизнес ёс зүйн стандартад нийцээгүйгээс үүдэн зохицуулагч байгууллагын торгууль тавиулах, санхүүгийн хохирол хүлээх, бизнесийн үнэ цэнэ болон нэр хүндэд сөргөөр нөлөөлөх эрсдэл;
- **Нэр хүндийн эрсдэл** - гэж компанийн нэр хүндэд сөргөөр нөлөөлж санхүүгийн хохирол хүлээх эрсдэл;
- **Стратегийн эрсдэл** - гэж оновчгүй бизнесийн шийдвэр, шийдвэрийн зохисгүй, бүрэн бус хэрэгжүүлэлт, зах зээлийн өөрчлөлтөд оновчтой хариу үйлдэл үзүүлээгүйн улмаас гарах алдагдлын эрсдэлийг ойлгоно.

Тэнгэр Даатгалын нийт даатгалын хариуцлага буюу нөөц санг нийт төлсөн нөхөн төлбөрийн хэмжээгээр авч үзэн зохистой хэмжээнд байгаа эсэхийг актуарын буцаан тестлэх аргаар шалгадаг. Ингэснээр даатгуулагчийн эрх ашгийг хамгаалж, хангалттай буюу зохистой хэмжээний нөөц сан байгуулсан эсэхийг тодорхойлон ажиллаж байна.

УДИРДЛАГЫН БАГ




Санхүү Хариуцсан Захирал
БАЛЖИРЫН ТУУЛ

Гүйцэтгэх Захирал
ОЙБЕК Н. ХАЛИЛОВ

Захиргаа Хариуцсан Захирал
ЧУЛУУНБААТАРЫН ХОСБАЯР

Андеррайтинг Хариуцсан захирал
БОЛОРБОЛДЫН ЗАЯА

КОМПАНИЙН БҮТЭЦ





ХЯНАН НИЙЦҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Тэнгэр Даатгал ХХК олон улсын стандарт, аргачлал, зөвлөмж болон улс хоорондын ойлголцол, Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагаагаа шударгаар явуулж үйл ажиллагаандаа компанийн сайн засаглалыг бүрдүүлэн, хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тус компани нь Монгол Улсын хууль тогтоомжийн шаардлагад нийцсэн Комплаенсын журам, Шүгэл үлээх бодлого, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журмыг компанийн бүх түвшинд мөрдүүлдэг.

Тэнгэр Даатгал ХХК нь Монгол Улсын Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон түүнтэй холбоотой бусад хууль тогтоомж, заавар, журмуудын хүрээнд харилцагчаа таньж мэдэх үйл ажиллагааг хэрэгжүүлж, компанийн үйл ажиллагаанд хянан нийцүүлэлт хийж, Монголбанкны Санхүүгийн мэдээллийн албанд бэлэн мөнгөний болон сэжигтэй гүйлгээний мэдээллийг тогтоосон хугацаанд тогтмол хүргүүлж, НҮБ-ын хориг жагсаалтад орсон иргэн, хуулийн этгээдэд даатгалын аливаа үйлчилгээ үзүүлэхээс татгалзаж байна.

2018 онд Тэнгэр Даатгал ХХК нь ISO 9001:2005 Чанарын удирдлагын тогтолцоог үйл ажиллагаандаа нэвтрүүлж, гэрчилгээ авсан нь тус компанийг комплаенсын удирдлагыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байгаа явдлын тод илрэл мөн.

Хууль эрх зүй, бизнесийн хувьсан өөрчлөгдөж байгаа орчинд бид комплаенсын үйл ажиллагаандаа өндөр ач холбогдол өгч сайжруулсаар байна. Дэлхийн тэргүүлэх компаниудын сайн жишгийг мөрдөж, Монгол улсын Авлигатай тэмцэх тухай хуулийг сахин ажилласнаар бид бизнесийг нээлттэй, ёс зүйтэй явуулах нийгмийн хариуцлагаа бүрэн ухамсарладаг юм. Компанийн бүх шатны ажилтнууд Ёс зүйн кодыг мөрдөн, Монгол улсын хуулийн хүрээнд ажлаа явуулах үүрэг хүлээсэн байдаг нь манай компани ил тод, хариуцлагатай байдлаа тодотгож засаглалаа байнга сайжруулсаар байгааг харуулдаг билээ.

ХАСБАНК

Иргэдийн болон Бизнес Банк

ХАСЛИЗИНГ

Санхүүгийн түрээсийн үйлчилгээ

ТЭНГЭР ДААТГАЛ

Даатгал

ТЭНГЭР
САНХҮҮГИЙН НЭГДЭЛ

ТЭНГЭР КАПИТАЛ

Хөрөнгө оруулалт

ГЛАШИЕР АССЕТ

Хөрөнгийн менежмент

ТИАНРОНГ

Бичил санхүү

ХАССЕКЬЮРИТИ

Харуул хамгаалалт

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ



Төлөөлөн Удирдах
Зөвлөлийн дарга
МАГВАНЫ БОЛДОО

М.Болд нь 2014 оны 7 сарын 10-наас ХасБанкны Гүйцэтгэх Захирлаар томилогдон ажиллаж байгаа бөгөөд ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-н гүйцэтгэх болон ХасБанкны ТУЗ-ийн гүйцэтгэх бус гишүүн, 2011 оноос ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна. ТэнГэр Санхүүгийн Нэгдлээс өмнө ХасБанкны Гүйцэтгэх захирлаар 2 жил, Ерөнхийлөгчөөр 3 жил ажиллажээ. М.Болд нь төрийн болон хувийн хэвшлийн банк, санхүүгийн байгууллагууд, мөн түүнчлэн Дэлхийн Банк, Олон улсын валютын сан зэрэг олон улсын санхүүгийн байгууллагад хорь гаруй жил ажиллаж, банкны салбарын эдийн засгийн бодлого, бүтцийн шинэчлэлийн асуудлаар гүнзгий мэргэшсэн юм. Тэрээр 1996-2000 онд Монгол Банк (Төв Банк)-ны дэд ерөнхийлөгчөөр ажиллаж байлаа. Мөн Зах зээл судлалын хүрээлэнд дэд захирал, Монголын Экспорт Импортын Банкны Гүйцэтгэх Захирал, ОХУ-ын Москва дахь Олон Улсын Хөрөнгө Оруулалтын Банк болон Эдийн Засгийн Хамтын Ажиллагааны Банкны ТУЗ-ийн гишүүн, Афганистан Улсын Төв Банкинд зөвлөх, Монголын Банкуудын Холбооны Дэд Ерөнхийлөгчөөр тус тус ажиллаж байв. М. Болд нь БНУУ-ын Будапешт хотын Эдийн Засгийн Их Сургуулийг Олон улсын эдийн засагч мэргэжлээр төгссөн бөгөөд АНУ-ын Колумбийн Их сургуульд эдийн засгийн бодлого, удирдлагын чиглэлээр олон улсын харилцааны магистрын зэрэг хамгаалжээ. Тэрээр Зээлийн Мэдээллийн Сан ХХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр ажиллахаас гадна 2011 оны 12-р сараас эхлэн Монголын Банкуудын Холбооны ерөнхийлөгчөөр сонгогдон ажиллаж байна. М. Болд нь Бүгд Найрамдах Исланд улсын Өргөмжит Консул.



Төлөөлөн Удирдах
Зөвлөлийн гишүүн
ГАНИБАЛЫН АМАРТУВШИН

Г.Амартүвшин нь Тэнгэр Санхүүгийн Нэгдлийн ерөнхий захирлаар 3 жил ажиллаж байгаад 2014 оны 7 сараас “ХасБанк”-ны Ерөнхий Захирлаар томилогдон ажиллаж байна.Казахстан улсын арилжааны томоохон банк болох Казкоммерц банкны эрсдэлийн удирдлагын газрын дарга, ерөнхий захирлын алба хашиж төслийн санхүүжилт болон зээлийн санхүүжилтийн чиглэлээр арваад жил ажилласан туршлагатай.Казкоммерц банкинд ажиллахын өмнө Г.Амартүвшин нь ABN AMRO Банкны Лондон, Амстердам болон Чикаго хотуудын салбарт ажиллаж байв. ABN AMRO банкны бүтцийн зээлийн хэлтэст ажиллаж байхдаа Европын газрын тос, шатдаг хий, эрчим хүч, харилцаа холбоо гэх мэтчилэн хэд хэдэн өндөр хэмжээний гүйлгээг хариуцан ажиллаж байжээ. Г.Амартүвшин нь хөдөлмөрийн гараагаа ABN AMRO дахь бэлэн мөнгөний менежментийн газраас эхэлсэн бөгөөд улмаар тэндээ Ерөнхий Эрсдэлийн Удирдлагын хэлтэст шилжин оржээ.Тэрбээр Бельги улсын Брюссель хотын Европын Их сургуулийн бизнесийн удирдлагын бакалаврын зэрэгтэй бөгөөд АНУ-ын Бостон хотын Харвардын бизнесийн сургуулийн, бизнесийн удирдлагын магистрын дипломтой.



Төлөөлөн Удирдах
Зөвлөлийн гишүүн
ОЙБЕК Н. ХАЛИЛОВ

2015 оны 9-р сарын 14-ний өдөр Ойбек Тэнгэр Санхүүгийн Нэгдэлд элсэж, Тэнгэр Даатгал ХХК-н Гүйцэтгэх захирал ба Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнээр томилогдсон юм. Тухайн албан тушаалд томилогдохоос 20+ жилийн өмнө ноён Халилов нь хувийн даатгалын салбарын American International Group Inc-д ажиллаж байсан байна. 1994-1999 он хүртэл 5 жилийн хугацаанд Англи улсын Лондон хотноо American International Group (AIG)-н улс төрийн эрсдлийн хамтарсан байгууллагад Гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан. Түүнчлэн 2000-2015 оны хугацаанд AIG-н Төв Ази ба Кавказ бүсийн ердийн даатгалын үйл ажиллагааг хариуцан ажилласан туршлагатай. Өөрийн мэргэжлийн карьерийн туршид тэрээр компаниудыг санхүү, өрсөлдөх чадвар, үйл ажиллагааны хувьд шинэ түвшинд хүргэсээр ирсэн ба эрчим хүч, хөрөнгө, хохирол, санхүүгийн даатгал, гэнэтийн ослын даатгал мөн улс төрийн эрсдлийн даатгалын талаар өргөн мэдлэгтэй нэгэн юм. Тэрээр өнгөрсөн 20 жилийн хугацаанд Америкийн Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын үйл ажиллагааг идэвхтэйгээр дэмжиж ирсэн ба Узбекистан, Казахстан ба Монгол улс дахь салбаруудын ТУЗ-н гишүүний албыг хашиж байжээ. 2016 онд Ойбек Монголын Даатгагчдын Холбооны даргаар томилогдож байсан ба 2018 оны 11 сард Монгол дахь Америкийн Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын ТУЗ-н даргаар сонгогдсон юм.



Төлөөлөн Удирдах
Зөвлөлийн гишүүн
ТОРСТЕН КЛАЙН БОЙНИНГ

ХасБанкны Эрсдэл хариуцсан захирлын албан тушаалд 2017 оны 1 дүгээр сарын 2-ны өдрөөс эхлэн Торстен Клайн Бойнинг ажиллаж байгаа бөгөөд Тэнгэр Даатгалын Төлөөлөн удирдах зөвлөлд мөн ажиллаж эхлээд байна. Тэрээр ХасБанкны Зээл, Үйл ажиллагааны эрсдэл болон Хянан нийцүүлэлтийн бодлогыг удирдан ажиллах бөгөөд Монголд ирэхээсээ өмнө Лондонд төвтэй үндэстэн дамнасан компани болох Стандарт чартеред банканд Засаглал, байгууллагын эрсдэлийн удирдлага хариуцсан захирлын албыг хашдаг байжээ. Ноён Торстен нь Азийн бүсийн хөгжингүй болон хөгжиж буй эдийн засагтай улс орнуудад санхүүгийн байгууллагын эрсдэлийн удирдлагын чиглэлээр нийт 16 жил ажилласан арвин туршлагатай юм. Мөн тэрээр орон нутгийн болон олон улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг санхүүгийн байгууллагад Хөрөнгийн болон Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх, Эрсдэлийн загварчлал боловсруулах чиглэлээр дагнан ажиллаж, зөвлөх үйлчилгээ үзүүлж байсан ба Basel II стандартыг Азийн 11 улсад хэрэгжүүлэхэд манлайлан оролцсон байна. Тэрээр Вильгелм хааны нэрэмжит Вестфальсийн Их Сургууль (University of Munster)-ийг Мэдээллийн системийн мастерын зэрэгтэй төгсөж, АНУ, Европын холбоо болон Ойрх Дорнодын зарим улсуудад мэргэжлээрээ ажиллаж байсан ба хамгийн сүүлд Стандарт чартеред банкны Сингапур дах салбар банканд дээд түвшний удирдах ажил гүйцэтгэж байв.



Төлөөлөн Удирдах
Зөвлөлийн гишүүн
ДОНОРОВЫН ГАНТУЛГА

Д.Гантулга нь санхүүгийн зөвлөх үйлчилгээний Гэрэгэ Партнерс ХХК-ийн ТУЗ-ийн даргаар ажилладаг бөгөөд 2017 оны 7 дугаар сараас эхлэн Тэнгэр Даатгал ХХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр ажиллаж байна. Гантулга нь актуарч мэргэжилтэй бөгөөд 2007 онд Их Британи улсын Лондон хотод Гранд Торнтон компанид актуарын шинжээчээр ажиллаж мэргэжлийн ажлын гараагаа эхэлсэн. Одоо Монголын Актуарчдын Нийгэмлэгийн УЗ-ийн даргаар ажилладаг. Өмнө нь хөрөнгө оруулалтын МЖТ ХХК-ийн гүйцэтгэх захирал, үнэлгээний Гэрэгэ Эстимэйт ХХК-ийн гүйцэтгэх захирал зэргээр бизнесийн салбарт ажиллаж байснаас гадна Монголбанкны Мөнгөний бодлогын зөвлөлийн хараат бус гишүүн, Хадгаламжийн даатгалын корпорацийн үндэсний хорооны гишүүн зэрэг орон тооны бус ажилд томилогдон ажиллаж банк, санхүүгийн салбарын бодлого боловсруулах ажилд мэргэжлийн туршлага хуримтлуулсан мэргэжилтэн юм. Тэрээр МУИС-ийг математикийн бакалавр, магистр, Их Британи улсын Манчестер Метрополитаны их сургуулийг MBA зэрэгтэй төгссөн.



ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Тэнгэр Даатгал ХХК-ын Хувьцаа эзэмшигч танаа,

Санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Дүгнэлт

Бид Тэнгэр Даатгал ХХК (цаашид “Компани” гэх) -ын 2018 оны 12 сарын 31-ний санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр тасалбар болгосон тайлант жилийн иж бүрэн орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бид, Компанийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний санхүүгийн байдал, уг өдрөөр тасалбар болгосон санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (цаашид “СТОУС” гэх)-ын дагуу үнэн, шударгаар илэрхийлж байна гэж дүгнэж байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (цаашид “АОУС” гэх)-ын дагуу гүйцэтгэсэн болно. Уг стандартуудын дагуу бидний хүлээх үүргийг энэхүү тайлангийн Санхүүгийн Тайлангийн Аудиттай холбоотой Аудиторын Үүрэг хэсэгт тусгасан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс баталсан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм (цаашид “НБЁЗОУСЗ-ын дүрэм” гэх)-ийн дагуу Компаниас хараат бус ба НБЁЗОУСЗ-ын дүрмийн дагуу бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргах хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж итгэж байна.

Бусад мэдээлэл

Компанийн удирдлага бусад мэдээллийн талаар үүрэг хүлээнэ. Бусад мэдээлэлд захирлууд ба гүйцэтгэх удирдлагын мэдэгдэлд агуулагдсан мэдээллүүд орох бөгөөд санхүүгийн тайлан болон энэхүү аудиторын дүгнэлт орохгүй.

Энэхүү санхүүгийн тайланд өгөх манай дүгнэлт нь бусад мэдээллийг хамраагүй бөгөөд бид бусад мэдээлэлд ямар нэгэн дүгнэлт өгөхгүй.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид дээр тодорхойлогдсон бусад мэдээллийг бэлэн болсон үед унших үүрэгтэй бөгөөд бусад мэдээлэл нь санхүүгийн тайлан эсвэл аудитын явцад цуглуулсан мэдээллээс материаллаг хэмжээний алдаатай эсэхийг авч үзэх ёстой. Бусад мэдээллийг уншиж, бусад мэдээлэл нь материаллаг хэмжээний зөрүүтэй эсвэл алдаатай байвал бид засаглах эрх бүхий этгээдэд мэдэгдэх үүрэгтэй. Үүнтэй холбоотойгоор ямар нэгэн мэдэгдэх зүйл байгаагүй болно.

Санхүүгийн Тайлантай холбоотой Удирдлага болон Засаглах Эрх Бүхий Этгээдийн Үүрэг

Удирдлага нь санхүүгийн тайлангаа СТОУС-ын дагуу бэлтгэн шударгаар илэрхийлэх, эдгээр санхүүгийн тайланг алдаа эсвэл санаатай зальт үйлдлээс үүсэлтэй материаллаг хэмжээний алдаагүйгээр бэлтгэж, шударгаар илэрхийлэхийн тулд удирдлагаас шаардлагатай гэж тогтоосон дотоод хяналтыг хэрэгжүүлэх үүрэгтэй.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ Компанийг татан буулгах, үйл ажиллагааг нь зогсоох, эсвэл үүнээс өөр боломжит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд Удирдлага Компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжийг үнэлэх, тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг ашиглан санхүүгийн тайлангаа бэлтгэх үүрэгтэй.

Засаглах эрх бүхий этгээд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

Санхүүгийн Тайлангийн Аудиттай холбоотой Аудиторын Үүрэг

Санхүүгийн тайлан нь бүхэлдээ алдаа эсвэл санаатай зальт үйлдлийн улмаас материаллаг хэмжээний алдаагүй илэрхийлэгдсэн эсэх талаар ул үндэслэлтэй нотолгоо олж авах болон бидний дүгнэлтийг агуулсан аудиторын тайлан гарган гэрээт ажлын гэрээнд заасан эрх бүхий этгээд болох та бүхэнд хүргүүлэх нь бидний зорилго юм. Энэхүү тайлангийн агуулгын хүрээнд бид аливаа бусад этгээдийн өмнө ямар нэг хариуцлага хүлээхгүй болно. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудит нь байнга материаллаг хэмжээний алдааг илрүүлдэг гэсэн баталгаа болохгүй. Алдаатай илэрхийлэл нь алдаа эсвэл санаатай зальт үйлдлээс үүсч болох ба дангаараа эсвэл нийтдээ эдгээр санхүүгийн тайланд үндэслэн шийдвэр гаргах санхүүгийн тайлангийн хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллаг гэж үздэг.

АОУС-ын дагуу аудитын нэг хэсэг болгож, бид аудитын туршид мэргэжлийн үнэлэмжээ ашиглан, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримталсан болно. Мөн түүнчлэн бид:

- Залилан болон алдаанаас үүсч болохуйц санхүүгийн тайлангийн материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлон үнэлж, уг эрсдэлүүдэд тохирох аудитын горимуудыг боловсруулан гүйцэтгэж, аудитын дүгнэлтийн үндэслэл болох хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоог олж авсан. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг. Учир нь залилангийн үед хуйвалдаан, хуурамчаар үйлдэх, санаатай орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг үл хэрэгжүүлэх явдлууд тохиолдсон байж болдог.
- Аудитын горимуудыг сонгохтой холбоотойгоор дотоод хяналтуудыг судалдаг ба энэ нь Компанийн дотоод хяналтын үр дүнтэй байдлын талаар дүгнэлт өгөх зорилгогүй болно.
- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын зохистой байдал болон удирдлагын бэлтгэсэн нягтлан бодох бүртгэлийн тооцоолол болон холбогдох тодруулгуудын бодитой байдлыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн тасралтгүй байх нөхцөлийг үргэлжлүүлэн хангах Компанийн чадварт мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал болон материаллаг тодорхой бус байдал үүссэн эсэхийг үнэлдэг. Хэрэв бид материаллаг хэмжээний тодорхой бус байдал байгаа гэж үзвэл аудиторын дүгнэлт болон санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулдаг ба уг тодруулгууд нь зохистой биш гэж үзсэн тохиолдолд бид дүгнэлтээ өөрчилдөг. Бидний дүгнэлт нь манай аудиторын тайлангийн өдөр хүртэлх олж авсан аудитын нотолгоон дээр үндэслэсэн байдаг. Хэдий тийм боловч ирээдүйд болох үйл явдал эсвэл нөхцөл байдал нь Компанийг үйл ажиллагаагаа явуулахад нь саад учруулж болох юм.
- Санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлдэг. Үүнд тодруулгаас гадна санхүүгийн тайланг үнэн зөв толилуулсан эсэхийг үнэлэхийн тулд ажил гүйлгээ, үйл явдлуудыг толилуулсан эсэхийг үнэлдэг.

Аудитор нь засаглах эрх бүхий этгээдтэй зөвхөн аудитын ажлын цар хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад илэрсэн ач холбогдол бүхий асуудлуудаар холбогддог ба үүнд аудитын үеэр аудиторын илрүүлсэн дотоод хяналтын мэдэгдэхүйц алдаа болон дутагдал орно.



Ц.Норжинбат
Захирал, МНБ
Делоитт Онч Аудит ХХК
2019 оны 3 сарын 26

2018

2017

ХӨРӨНГӨ

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	2,407,902	1,330,533
Хугацаат хадгаламж	14,393,796	12,224,633
Засгийн газрын ба компанийн бонд	937,138	1,248,547
Дансны ба бусад авлага	1,237,877	1,420,784
Орлогын албан татварын авлага	-	5,504
Даатгалын гэрээний хойшлогдсон зардал	622,829	495,920
Давхар даатгагчийн орлогод тооцоогүй нөөц	2,483,704	1,253,362
Урьдчилж төлсөн зардал	177,776	164,482
Бараа материал	88,342	68,160
Хойшлогдсон татварын хөрөнгө	15,546	3,630
Үндсэн хөрөнгө	1,148,583	1,025,236
Биет бус хөрөнгө	123,072	50,549
Нийт хөрөнгө	23,636,565	19,291,340

ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ

Өр төлбөр

Даатгалын гэрээний нөөц сангууд	12,001,159	9,941,007
Дансны ба бусад өглөг	2,646,087	1,676,761
Орлогын албан татварын өглөг	7,275	-
Нийт өр төлбөр	14,654,521	11,617,768

Эздийн өмч

Энгийн хувьцаа	5,000,000	4,250,000
Нэмж төлөгдсөн капитал	130,000	130,000
Хуримтлагдсан ашиг	3,852,044	3,293,572
	8,982,044	7,673,572
Нийт өр төлбөр ба эздийн өмч	23,636,565	19,291,340

ТЭНГЭР ДААТГАЛ ХХК
ИЖ БҮРЭН ОРЛОГЫН ТАЙЛАН
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2018 ОН
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)

	2018	2017
Орлогод тооцсон цэвэр хураамж		
Даатгалын нийт орлогод тооцсон хураамж	12,483,965	10,879,834
Давхар даатгагчид ногдох хураамж	(4,271,568)	(3,763,505)
Орлогод тооцсон цэвэр хураамж	8,212,397	7,116,329
Нөхөн төлбөрийн зардал, цэвэр дүнгээр		
Нөхөн төлбөрийн зардал	(5,407,720)	(5,089,832)
Давхар даатгагчид ногдох нөхөн төлбөр	1,857,354	2,511,713
Нөхөн төлбөрийн зардал	(3,550,366)	(2,578,119)
Даатгалын үйл ажиллагааны цэвэр орлого	4,662,031	4,538,210
Санхүүгийн ба бусад орлого	2,466,021	2,272,600
Бусад (гарз) ба олз	(7,090)	48,973
Борлуулалт, ерөнхий ба удирдлагын зардал	(4,998,764)	(4,267,026)
Татварын өмнөх ашиг	2,122,198	2,592,757
Орлогын татварын зардал	(230,394)	(234,560)
Цэвэр ашиг	1,891,804	2,358,197
Бусад иж бүрэн орлого	-	-
Нийт иж бүрэн орлого	1,891,804	2,358,197



Утас: (+976) 1800-1889

Хаяг: CITY CENTER, 11 давхар Б.Алтангэрэлийн гудамж
5, Бага тойруу, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо,
Улаанбаатар, Монгол улс

Э-шуудан: Insurance@tengerinsurance.mn

Вэб: www.tengerdattal.mn, www.edaattal.mn